# МОНГОЛ УЛС
# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
# ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 08 өдөр          Дугаар А/131          Есөнбулаг

Улсын аварга малчдад хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дэх заалт, 14.4 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 30 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 06 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Улсын хошой аварга малчин" Төгрөг сумын Цагаанхайрхан багийн малчин Г.Энхтөр, "Улсын аварга малчин"-аар шалгарсан Баян-Уул сумын Хүйсийн говь багийн малчин Ш.Батболд, Бугат сумын Биж багийн малчин Р.Ширчиннямаа, Дарив сумын Жавхлант багийн малчин Н.Батболд, Халиун сумын Чацран багийн малчин Б.Бум-Эрдэнэ, Тайшир сумын Далан багийн малчин Б.Мөнхзаяа, Тонхил сумын Тамч багийн малчин С.Мөнхбат, Чандмань сумын Талын шанд багийн малчин Д.Гүнчиг, Чандмань сумын Эрдэнэ-Уул багийн малчин Ц.Өрнөхбуян, Шарга сумын Хамтын хүч багийн малчин П.Энхбаатар, Эрдэнэ сумын Өлзийт багийн малчин Ц.Батболд, "Улсын аварга тариаланч" Тайшир сумын Хуримт багийн тариаланч Д.Эрдэнэбаатар, "Улсын аварга саальчин" Шарга сумын Баянгол багийн саальчин Д.Сувд нарт хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах зардлыг хавсралтаар батлсугай.

2.Шаардагдах 4,780,205 (дөрвөн сая долоон зуун наян мянга хоёр зуун тав) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА          О.АМГАЛАНБААТАР

[illegible]

Аймгийн Засаг даргын 2024 оны
02 дугаар сарын 08-ны өдрийн А/151 дугаар
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

| Д/д | Шагналын төрөл /малчин өрхийн тоо/ | Бэлэг дурсгалын зүйлс | Тоо, ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Улсын хошой аварга малчин, аварга малчин, тариаланч, саальчин | Өргөмжлөл | 13 | 50,000 | 650,000 |
| | | Хадаг | 13 | 8000 | 104,000 |
| 2 | | Чихэр | 12 уут | 23,350 | 280,200 |
| 3<br>4 | | Календар | 13 | 5000 | 65,000 |
| 5 | | Бичвэр | 218 | 4500 | 981,000 |
| 6 | | Тээврийн зардал /Улсын аваргын гэр/ | 11 | 245,455 | 2,700,005 |
| НИЙТ ЗАРДАЛ | | | | | 4,780,205 |

__oOo__